



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2016 оны 03 сарын 09 өдөр

Дугаар 72

Улаанбаатар хот

Г

Г

Мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрлийг хүчингүй болгож, нөхөн олгох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.17 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.3 дахь заалт, Захиргааны хэргийн анхан шатны 20 дугаар шүүхийн 2015 оны 05 сарын 28-ны өдрийн 232 дугаар шийдвэрийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Чимэддоржийн Соёлмаа албан ёсоор өөрийн нэрийг сольсон тул Эрүүл мэндийн сайдын 2014 оны 254 дүгээр тушаалаар олгосон эм барих үйл ажиллагаа эрхлэх ЭН0002416 сери, 0002416 дугаарын зөвшөөрлийг хүчингүйд тооцож, Чимэддоржийн Хуягаа нэрээр ЭН0003324 сери, 0003324 дугаартай эм барих зөвшөөрлийг нөхөн олгосугай.
2. Зөвшөөрлийн гэрчилгээг баталгаажуулж олгон, төвийн цахим хуудас, зөвшөөрлийн мэдээний санд байршуулж нийтэд мэдээлэхийг Эрүүл мэндийн хөгжлийн төвийн захирал (Ч.Бат-Эрдэнэ)-д үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга, Эмнэлгийн мэргэжилтний зөвшөөрлийн зөвлөлийн дарга (С.Ламбаа)-д даалгасугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ц.ОЮУНБААТАР



080231